



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/40/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар

Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	17
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЭМЧ,
ДАРГА Б.МӨНХБАТ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.07 № 26
танай 2025/01/25 -ны № 1/53 -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.16-т заасны дагуу орон нутгийн төсвөөс тайлант онд тогтмол зардал болох 724,175.5 мянган төгрөгийн зардлыг санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 27,722,386.4 мянган төгрөгийг нэхэмжилснээс хяналтаар 2,091,015.4 мянган төгрөг хасуулж, өмнөх оны авлага 1,440,775.8 мянган төгрөг, тайлант оны санхүүжилт 25,631,371.0 мянган төгрөг авахаас 24,680,846.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 2,391,300.3 мянган төгрөгийн авлага тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Нэгдсэн эмнэлгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 бүлэг 59 зорилтын хүрээнд 220 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

009020016

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,966,747,690.07</u>	<u>4,217,407,451.79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,268,159.30	236,606,056.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,268,159.30	236,606,056.00
3121	Төгрөг	18,268,159.30	236,606,056.00
31211	Төрийн сангийн харилцах	18,268,159.30	236,606,056.00
33	АВЛАГА	1,443,925,721.00	2,394,157,362.90
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,440,775,819.00	2,391,300,260.90
335	Бусад авлага	3,149,902.00	2,857,102.00
3351	Байгууллагаас авах авлага	3,149,902.00	2,857,102.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,504,553,809.77	1,586,644,032.89
351	Түүхий эд материал	568,785,263.16	645,873,381.44
35130	Эм боох материал	568,785,263.16	645,873,381.44
354	Хангамжийн материал	935,768,546.61	940,770,651.45
35410	Бичиг хэргийн материал	68,030,880.00	49,587,990.00
35420	Аж ахуйн материал	32,517,204.67	32,769,860.27
35430	Сэлбэг хэрэгсэл	58,169,350.00	55,659,850.00
35440	Түлш, шатах тослох материал	7,533,579.00	4,306,180.00
35450	Барилгын засварын материал	6,100,200.00	8,654,685.00
35470	Бусад хангамжийн материал	763,417,332.94	789,792,086.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,575,198,494.76</u>	<u>22,743,297,307.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22,575,198,494.76	22,743,297,307.20
392	Биет хөрөнгө	19,275,785,244.68	17,145,110,932.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,108,561,735.41	12,110,661,735.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,108,776,832.01)	(2,597,955,008.49)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	679,422,582.00	1,227,141,173.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(256,167,343.39)	(368,577,724.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,237,318,687.74	14,179,446,660.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,163,290,574.43)	(8,043,049,916.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	310,821,006.34	332,893,406.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	(120,955,007.73)	(187,863,980.18)
39214	Бусад үндсэн хөрөнгө	919,160,668.67	948,475,865.77
39215	Хуримтлагдсан элэгдэл	(335,264,915.92)	(461,621,347.47)
39217	Ном	4,955,238.00	5,560,068.00
393	Биет бус хөрөнгө	3,299,413,250.08	5,598,186,375.00
39301	Програм хангамж	9,813,500.00	10,713,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,216,249.92)	(6,343,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,293,816,000.00	5,593,816,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>25,541,946,184.83</u>	<u>26,960,704,758.99</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,484,381,176.52</u>	<u>4,003,735,342.54</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,484,381,176.52	4,003,735,342.54
413	Өглөг	2,484,381,176.52	4,003,735,342.54

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	843,128,165.53	934,706,793.39
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,457,491,356.99	2,850,259,316.16
4136	Бусад өглөг	183,761,654.00	218,769,232.99
41361	Байгууллагад төлөх өглөг	182,323,654.00	209,274,232.99
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,438,000.00	9,495,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>23,057,565,008.31</u>	<u>22,956,969,416.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	23,057,565,008.31	22,956,969,416.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,626,717,083.16	7,626,717,083.16
51101	Өмч: - төрийн	7,626,717,083.16	7,626,717,083.16
512	Хуримтлагдсан үр дүн	7,351,807,869.96	7,251,212,278.10
51210	Өмнөх үеийн үр дүн	7,351,807,869.96	7,351,807,869.96
51220	Тайлант үеийн үр дүн	-	(100,595,591.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,079,040,055.19	8,079,040,055.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>25,541,946,184.83</u>	<u>26,960,704,758.99</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	24,648,587,463.39	32,518,201,245.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,380,277,029.39	6,162,654,758.17
120	Нийтлэг татварын бус орлого	1,379,510,932.93	2,416,100,490.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,379,510,932.93	2,401,624,312.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	674,850,109.33	862,482,455.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	356,077,105.17	976,299,897.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	348,583,718.43	562,841,959.10
120005	Түрээсийн орлого	-	14,476,178.00
122	Тусламжийн орлого	3,000,766,096.46	3,746,554,267.66
122001	Хандив тусламж /дотоод/	3,000,766,096.46	3,746,554,267.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,268,310,434.00	26,355,546,487.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	724,175,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	724,175,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,268,310,434.00	25,631,370,987.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,268,310,434.00	25,631,370,987.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	27,030,458,295.15	32,613,151,461.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,030,458,295.15	32,613,151,461.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,021,529,884.15	31,683,885,953.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,849,737,918.50	17,191,541,827.15
210101	Үндсэн цалин	7,922,605,515.49	9,469,136,313.23
210102	Нэмэгдэл	4,697,338,871.42	5,952,815,490.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500,587,707.95	703,991,181.47
210104	Урамшуулал	729,205,823.64	1,065,598,842.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,752,691,300.77	2,230,253,643.89
210201	Тэтгэврийн даатгал	1,220,886,874.37	1,506,957,128.35
210202	Тэтгэмжийн даатгал	138,877,918.14	174,956,606.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	108,180,735.13	135,957,961.63
210204	Ажилгүйдлийн даатгал	47,768,154.15	82,144,916.28
210205	Эрүүл мэндийн даатгал	236,977,618.98	330,237,030.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	658,967,591.20	732,291,185.97
210301	Гэрэл, цахилгаан	208,033,092.50	236,552,287.72
210302	Түлш, халаалт	188,685,513.05	179,324,572.03
210303	Цэвэр, бохир ус	262,248,985.65	316,414,326.22
2104	Хангамж, бараа материалын зардал	627,360,979.68	392,112,485.93
210401	Бичиг хэрэг	16,147,470.00	23,869,290.00
210402	Тээвэр, шатахуун	182,596,470.68	156,704,003.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,905,200.65	21,066,384.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,710,000.00	9,590,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	78,743,802.00	180,882,308.14
210408	Бараа материал акталсны зардал	323,258,036.35	-
2105	Нормативт зардал	6,242,565,200.33	7,046,338,085.68
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,357,263,844.33	6,109,316,910.68
210502	Хоол, хүнс	884,901,356.00	936,621,175.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,202,643.00	239,127,379.15

7

ХТ05430@9022899

210604	Урсгал засвар	200,202,643.00	239,127,379.15
2107	Томилолт, зочны зардал	1,185,310.00	5,179,600.00
210702	Дотоод албан томилолт	1,185,310.00	5,179,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,671,884.25	94,842,356.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,291,054.08	27,086,681.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,796,800.00	579,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,163,310.00	9,708,222.21
210804	Тээврийн хэрэгслийн татвар	822,616.00	599,558.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	495,000.00	550,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,400,000.00	19,428,000.00
210807	Газрын төлбөр	8,646,041.00	10,681,384.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,565,563.17	6,775,210.92
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,491,500.00	19,433,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,575,147,056.42	3,752,199,389.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,158,047.00	27,377,624.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,610,000.00	4,485,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,548,379,009.42	3,720,336,765.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,928,411.00	929,265,507.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,928,411.00	921,937,318.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	593,115,228.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	313,171,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,928,411.00	15,651,090.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,328,189.91
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,328,189.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,381,870,831.76)	(94,950,216.57)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	378,064.00	917,124.71
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	378,064.00	917,124.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	6,562,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	6,562,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	378,064.00	(5,645,375.29)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,381,492,767.76)	(100,595,591.86)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	19,849,550,364.33	27,252,067,490.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,022,231,749.33	1,847,045,445.20
120	Нийтлэг татварын бус орлого	1,022,231,749.33	1,847,045,445.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,022,231,749.33	1,832,276,467.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	674,850,109.33	855,707,244.59
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	347,381,640.00	976,569,222.61
120005	Түрээсийн орлого	-	14,768,978.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,827,318,615.00	25,405,022,045.10
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	724,175,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	724,175,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,827,318,615.00	24,680,846,545.10
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,827,318,615.00	24,680,846,545.10
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	20,592,416,021.17	26,888,395,783.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,592,416,021.17	26,888,395,783.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,583,487,610.17	25,964,680,275.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,295,106,488.18	17,029,111,895.91
210101	Үндсэн цалин	7,690,704,646.45	9,046,712,139.09
210102	Нэмэгдэл	4,696,557,139.28	5,900,932,364.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500,587,707.95	703,105,078.69
210104	Урамшуулал	407,256,994.50	1,378,362,313.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,464,194,565.56	2,301,104,947.27
210201	Тэтгэврийн даатгал	1,022,991,934.92	1,546,602,534.59
210202	Тэтгэмжийн даатгал	115,200,919.85	184,809,255.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	89,674,736.30	141,410,129.10
210204	Ажилгүйдлийн даатгал	21,334,269.66	80,073,251.36
210205	Эрүүл мэндийн даатгал	214,992,704.83	348,209,776.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	563,586,319.15	827,672,458.02
210301	Гэрэл, цахилгаан	190,357,801.60	254,227,578.62
210302	Түлш, халаалт	138,959,490.02	229,050,595.06
210303	Цэвэр, бохир ус	234,269,027.53	344,394,284.34
2104	Хангамж, бараа материалын зардал	294,476,846.65	279,653,335.80
210401	Бичиг хэрэг	40,801,350.00	13,693,600.00
210402	Тээвэр, шатахуун	166,189,650.00	158,998,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,905,200.65	20,923,185.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,900,000.00	9,722,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,680,646.00	76,315,350.00
2105	Нормативт зардал	4,659,663,264.05	5,123,466,520.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,896,704,492.39	4,210,095,925.68
210502	Хоол, хүнс	761,958,771.66	912,370,594.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00


2106	Эд хогшил, урсгал засварын зардал	174,650,862.50	267,278,073.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,922,700.00	7,022,506.00
210602	Тавилга	975,000.00	1,320,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,979,400.00	15,503,840.00
210604	Урсгал засвар	135,773,762.50	243,431,727.00
2107	Томилолт, зочны зардал	1,185,310.00	5,179,600.00
210702	Дотоод албан томилолт	1,185,310.00	5,179,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,847,571.08	92,865,123.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,650,638.08	33,502,181.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,796,800.00	579,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,163,310.00	9,708,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	822,616.00	599,558.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	495,000.00	550,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,400,000.00	19,428,000.00
210807	Газрын төлбөр	8,645,957.00	10,681,384.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,873,250.00	17,816,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,776,383.00	38,348,322.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,273,083.00	35,102,322.21
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,503,300.00	3,246,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,928,411.00	923,715,507.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,928,411.00	916,387,318.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	593,115,228.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	313,171,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,928,411.00	10,101,090.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,328,189.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(742,865,656.84)	363,671,706.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	468,325,456.00	145,333,810.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	468,325,456.00	145,333,810.00
2200	Дотоод эх үүсвэрээр	468,325,456.00	145,333,810.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	468,325,456.00	145,333,810.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(468,325,456.00)	(145,333,810.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,211,191,112.84)	218,337,896.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,229,459,272.14	18,268,159.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,268,159.30	236,606,056.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	9,733,300,637.72	25,439,057,776.07
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	9,733,300,637.72	25,439,057,776.07
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,381,492,767.76)	(2,381,492,767.76)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,351,807,869.96	23,057,565,008.31
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,351,807,869.96	23,057,565,008.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,351,807,869.96	23,057,565,008.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(100,595,591.86)	(100,595,591.86)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,251,212,278.10	22,956,969,416.45



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,268,159.30	18,268,159.30	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,596,229,600.00	27,026,401,403.69	(5,569,828,196.31)	82.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,596,229,600.00	27,026,401,403.69	(5,569,828,196.31)	82.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,304,186,900.00	26,110,014,085.69	(5,194,172,814.31)	83.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,096,600,800.00	17,029,111,895.91	(1,067,488,904.09)	94.10
210101	Үндсэн цалин	9,929,611,700.00	9,046,712,139.09	(882,899,560.91)	91.11
210102	Нэмэгдэл	6,392,530,700.00	5,900,932,364.50	(491,598,335.50)	92.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	688,189,600.00	703,105,078.69	14,915,478.69	102.17
210104	Урамшуулал	1,086,268,800.00	1,378,362,313.63	292,093,513.63	126.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,532,185,400.00	2,301,104,947.27	(231,080,452.73)	90.87
210201	Тэтгэврийн даатгал	1,896,390,800.00	1,546,602,534.59	(349,788,265.41)	81.56
210202	Тэтгэмжийн даатгал	156,670,200.00	184,809,255.40	28,139,055.40	117.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	115,177,300.00	141,410,129.10	26,232,829.10	122.78
210204	Ажилгүйдлийн даатгал	67,302,900.00	80,073,251.36	12,770,351.36	118.97
210205	Эрүүл мэндийн даатгал	296,644,200.00	348,209,776.82	51,565,576.82	117.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	951,265,300.00	827,672,458.02	(123,592,841.98)	87.01
210301	Гэрэл, цахилгаан	286,530,900.00	254,227,578.62	(32,303,321.38)	88.73
210302	Түлш, халаалт	315,918,400.00	229,050,595.06	(86,867,804.94)	72.50
210303	Цэвэр, бохир ус	348,816,000.00	344,394,284.34	(4,421,715.66)	98.73
2104	Хангамж, бараа материалын зардал	389,306,300.00	281,240,135.80	(108,066,164.20)	72.24
210401	Бичиг хэрэг	77,868,900.00	13,693,600.00	(64,175,300.00)	17.59
210402	Тээвэр, шатахуун	180,998,700.00	158,998,700.00	(22,000,000.00)	87.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,133,700.00	20,923,185.80	1,789,485.80	109.35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,699,200.00	9,722,500.00	(1,976,700.00)	83.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	99,605,800.00	77,902,150.00	(21,703,650.00)	78.21
2105	Нормативт зардал	8,541,322,800.00	5,123,466,520.48	(3,417,856,279.52)	59.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,472,778,400.00	4,210,095,925.68	(3,262,682,474.32)	56.34
210502	Хоол, хүнс	1,058,544,400.00	912,370,594.80	(146,173,805.20)	86.19
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000,000.00	1,000,000.00	(9,000,000.00)	10.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	593,239,800.00	400,293,253.00	(192,946,547.00)	67.48
210601	Багаж, техник, хэрэгсэл	204,762,400.00	106,559,686.00	(98,202,714.00)	52.04
210602	Тавилга	5,250,000.00	5,250,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,803,800.00	22,743,840.00	(18,059,960.00)	55.74
210604	Урсгал засвар	342,423,600.00	265,739,727.00	(76,683,873.00)	77.61
2107	Томилолт, зочны зардал	5,897,300.00	5,179,600.00	(717,700.00)	87.83
210702	Дотоод албан томилолт	5,897,300.00	5,179,600.00	(717,700.00)	87.83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,224,700.00	94,369,953.00	(13,854,747.00)	87.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,344,600.00	33,502,181.00	(2,842,419.00)	92.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,930,100.00	579,800.00	(8,350,300.00)	6.49
210803	Даатгалын үйлчилгээ	9,708,200.00	9,708,200.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	599,600.00	599,558.00	(42.00)	99.99
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	550,000.00	550,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,542,000.00	20,328,000.00	(1,214,000.00)	94.36
210807	Газрын төлбөр	10,681,400.00	10,681,384.00	(16.00)	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	648,000.00	-	(648,000.00)	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	19,770,800.00	18,420,830.00	(1,349,970.00)	93.17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,144,500.00	47,575,322.21	(38,569,177.79)	55.23



210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,857,000.00	44,329,322.21	(22,527,677.79)	66.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,287,500.00	3,246,000.00	(16,041,500.00)	16.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,292,042,700.00	916,387,318.00	(375,655,382.00)	70.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,292,042,700.00	916,387,318.00	(375,655,382.00)	70.93
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	681,939,300.00	593,115,228.00	(88,824,072.00)	86.97
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	599,653,400.00	313,171,000.00	(286,482,400.00)	52.23
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,450,000.00	10,101,090.00	(348,910.00)	96.66
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,596,229,600.00	27,244,739,300.39	(5,351,490,299.61)	83.60
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	840,000,000.00	716,847,310.09	(123,152,689.91)	85.33
132001	Орон нутгийн төсвөөс	840,000,000.00	716,847,310.09	(123,152,689.91)	85.33
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,501,722,400.00	24,680,846,545.10	(4,820,875,854.90)	83.66
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,501,722,400.00	24,680,846,545.10	(4,820,875,854.90)	83.66
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,254,507,200.00	1,847,045,445.20	(407,461,754.80)	81.93
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	859,198,200.00	855,707,244.59	(3,490,955.41)	99.59
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,377,737,600.00	991,338,200.61	(386,399,399.39)	71.95
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	17,571,400.00		(17,571,400.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,268,159.30	18,268,159.30	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	236,606,056.00	236,606,056.00	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	641.00	578.00	37.00	106.84
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	433.00	467.00	34.00	107.85
620003	Үйлчлэх ажилтан	107.00	110.00	3.00	102.80
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг нь эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлдэг төрийн байгууллага бөгөөд эмнэлгийн удирдлага, хүний нөөцийн ур чадвар, манлайллыг дээшлүүлж, чанарын менежментийн тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэн, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, зохион байгуулах үйлчилгээг олон улсын жишгээр хөгжүүлэх эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлэг нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/11 дүгээр тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нэгдсэн эмнэлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,418,758.5 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,268.2	236,606.1	218,337.9
Авлага	1,443,925.7	2,394,157.4	950,231.7
Бараа материал	1,504,553.8	1,586,644.0	82,090.2
Үндсэн хөрөнгө	22,575,198.5	22,743,297.3	168,098.8
Нийт хөрөнгө	25,541,946.2	26,960,704.7	1,418,758.5
Өр төлбөр	2,484,381.2	4,003,735.3	1,519,354.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	23,057,565.0	22,956,969.4	(100,595.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	25,541,946.2	26,960,704.7	1,418,758.5

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансанд 27,252,067.5 мянган төгрөгийн орлого орж, 27,033,729.6 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд бие даасан байдалд бүрэн шилжсэнтэй холбоотойгоор зарцуулаагүй 236,606.1 мянган төгрөг төрийн сангийн дансанд үлдсэн байна.

Авлагын өсөлт нь Эрүүл мэндийн даатгалын сангаас 2,391,300.3 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан, 2,857.1 мянган төгрөгийн түрээсийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82,090.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,247,711.5 мянган төгрөг, хандив, тусламжаар 563,489.7 мянган төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газраас 84,406.0 мянган төгрөг, бусад байгууллагаас 302,746.3 мянган төгрөгийн материалыг хүлээн авч, Ерөнхий эмчийн 2024 оны А/58, А/130, А/132 дүгээр тушаалаар 50,640.1 мянган төгрөгийн материалыг акталж, 6,581,354.6 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаанд зарцуулснаас шалтгаалжээ. Бараа материалын үлдэгдэлд үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой эм боох материал 40.7 хувийг, бусад хангамжийн материал 35.2 хувийг тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн өсөлт нь төсвийн хөрөнгөөр 148,443.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэн, хандив, тусламжаар 3,755,445.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын 39 дүгээр тогтоолоор 31,500.0 мянган төгрөгийн фургон маркийн автомашин шилжүүлсэн, 27,550.0 төгрөгийн 3 автомашиныг акталсан, тайлант онд 3,720,336.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалжээ.

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт бүрэн орж ирээгүйгээс 4,003,735.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 22,956,969.4 мянган төгрөг болж, 100,595.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,655,819.7 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 24,902,121.9 мянган төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 5,162,143.6 мянган төгрөгөөр бууруулж, 21,395,798.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн цалингийн зардлыг 3,413,841.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 199,263.7 мянган төгрөг, бичиг хэргийн зардлыг 42,459.8 мянган төгрөг, шатахууны зардлыг 144,432.5 мянган төгрөгөөр тус тус бууруулсантай холбоотой байна.

Тайлант онд төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардлыг 5,117,633.9 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 776,112.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр батлагдсан төсвийг 6,432,957.4 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх 31,756,229.6 мянган төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс 17,571.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 859,198.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,377,737.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 29,501,722.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 840,000.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 855,707.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 991,338.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 724,175.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 24,680,846.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 27,026,401.4 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсвөөс зарцуулаагүй үлдсэн 7,328.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 236,606.0 мянган төгрөг зарцуулаагүй үлдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт бүрэн төвлөрөөгүйгээс төсвийн гүйцэтгэл 27,026,401.5 мянган төгрөг буюу 82.9 хувьтай гарч, цалин хөлс, эм, эмнэлгийн хэрэгслийн өр үүссэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ	32,596,229.6	27,026,401.5	(5,569,828.1)	82.9
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	28,650,502.5	23,828,655.5	(4,821,847.0)	83.2
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	10,450.0	10,101.1	(348.9)	96.6
1.3	81611- Төр хариуцах эмнэлгийн тусламж	71,839.5	-	(71,839.5)	-
1.4	81639-Төр төлбөрийг нь хариуцах эмийн зардал	215,517.9	101,226.5	(114,291.4)	46.9
1.5	83601-Олон нийтийн байгууллагаас олгосон	6,395.3	6,395.3	-	100.0
1.6	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	46,627.0	31,627.0	(15,000.0)	67.8
1.7	83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан	2,738,995.5	2,316,086.9	(422,908.6)	84.5
1.8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	855,901.9	732,309.2	(123,592.7)	85.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Эрүүл мэндийн яамнаас “Орбис-Чихрийн шижингийн ретинопатийн тусламж” төсөлд 6,395.0 мянга, эрүүл мэндийг дэмжих төвөөр эрт илрүүлэг үзлэгт эрүүл мэндийн даатгалын сангаас 861,631.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөл хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийт 12,132 иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд үнэ төлбөргүй хамрагдсан байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтаар 4 төсөл, арга хэмжээний 1,556,908.6 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 4 төсөл, арга хэмжээний 234,000.0 мянган төгрөг, нийт 1,790,908.6 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6 төсөл, арга хэмжээнд 1,612,615.2 мянган төгрөгийн гэрээ байгуулсан бол нормын хувцас, зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжийн сэлбэг нийлүүлэх зэрэг тендер шалгаруулалт нь төсөв батлагдаагүйгээс шалтгаалж зарлагдаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Шилэн данс, орлогын бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Батмягмар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/53 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 23,622,434.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 236,224.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасны дагуу байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 7,328.2 мянган төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 156,918.3 мянган төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн 17,505.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, бүртгэгдээгүй газар болон Төлөөлөн удирдах зөвлөл байгуулахтай холбоотой 2 зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлт 90 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	90.00
Төлбөрийн акт	3	17,505.2	3	17,505.2	100.00
Нийт дүн	5	17,505.2	5	17,505.2	100.00

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчаар анхаарах дараах асуудлууд байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.7 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл одоог хүртэл байгуулаагүй нь Эрүүл мэндийн яамнаас нэгдсэн шийдвэр гаргахтай холбоотойгоор хүлээгдэж байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг хэрэгжүүлээгүйгээс Эрүүл мэндийн яамны 2024 оны 2/2782 тоот албан бичгийн дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны Б/77 дугаар тушаалаар Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, даргад 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан тул үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшуулал олгосон байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 180,267.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 2,410.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 15,170.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажиллах 162,686.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах 2 зөрчилд нийт 2,410.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Үүнд:

1. Орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгохдоо Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241, 2024 оны 128 дугаар тогтоолуудаар баталсан цалингийн доод хэмжээг баримтлаагүйгээс 6 албан хаагчид 1,778.6 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан *“Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 2.2-т* заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын менежментийн албаны дарга Б.Мандахцэцэгийг батлагдаагүй орон тоо болох эрчим хүч хэмнэлтийн менежер албан тушаалд хавсран ажиллуулж 631,800.00 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5-д, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Тайлант онд байгууллагын дарга, санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 15,170.4 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол *“Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3.2-д* заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг арилгах таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

5.3 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орлогын дансны үлдэгдлийг тулган шалгахад хэвтэн эмчлүүлсний хамтын төлбөр 4,450.0 мянган төгрөг, эмнэлгийн халдвартай хог хаягдлын төлбөр 1,318.6 мянган төгрөг, нийт 5,768.6 мянган төгрөгийн төлбөрийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.1-т заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасны дагуу санхүүгийн тайланд тусгаагүй дээрх орлогыг эхний хагас жилийн санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнах.

Тайлангийн 4.4.1-т дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил болон дээрх зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алдаа илрээгүй.	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан	Тоо	Дүн
Орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгохдоо цалингийн доод хэмжээг баримтлаагүйгээс 6 албан хаагчид илүү олгосон	1	1,778.7	1	1,778.7	-	-	-	-	-	-	-	-
Байгууллагын менежментийн албаны даргад батлагдаагүй орон тоо болох эрчим хүч хэмнэлтийн менежер албан тушаалд хавсран ажиллуулж нэмэгдэл хөлс олгосон	1	631.8	1	631.8	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд байгууллагын дарга, санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалттай давхардуулан урамшуулал олгосон	1	15,170.4	-	-	1	15,170.4	-	-	-	-	-	-
Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулган шалгахад хэвтэн эмчлүүлсний хамтын төлбөр, эмнэлгийн халдвартай хог хаягдлын төлбөрийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна	1	5,768.6	-	-	-	-	1	5,768.6	-	-	-	-
Дүн	4	23,349.5	2	2,410.5	1	15,170.4	1	5,768.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 4 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 3 тушаал, шийдвэр мэдээлээгүй байна.	1	156,918.3	-	-	-	-	1	156,918.3
Дүн	1	156,918.3	-	-	-	-	1	156,918.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	5	180,267.8	2	2,410.5	1	15,170.4	2	162,686.9